



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/995

Мандалговь

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн  
дунд хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.4.2, 2.1.4.2.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын Сувилагчдын өдрийг тохиолдуулан аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран сувилагч, эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд “Бидний сувилагч-бидний ирээдүй-2023” хэлэлцүүлэг зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээний зардалд шаардагдах 1,400,000 (Нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823100782

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын  
12 -ны өдрийн 4 дугаар захирамжийн хавсралт



СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЦАЙНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Цайны зардал	200 хүн	7,000	1,400,000
	Нийт дүн			1,400,000